



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/3

Улаанбаатар хот

Бүтэц шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын зохион байгуулалтын бүтэц дүрмийг нэгдүгээр хавсралтаар, Улсын филарманийн зохион байгуулалтын бүтэц, дүрмийг хоёрдугаар хавсралтаар, Хүүхэлдэйн театрын зохион байгуулалтын бүтэц дүрмийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтцийн дагуу ажлын байрыг оновчтой тогтоон ажиллахыг Дуурь, бүжгийн эрдмийн театрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Мөнхзул), Улсын драмын эрдмийн театрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Наранбаатар), Хүүхэлдэйн театрын захирал (З.Баянзул)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай" А/173, 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай" А/200 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

Сүртгэлийн дугаар: 13

ХУУЛБАР ХУВЬ

Дилил дор
(Албан тушаалын нэр)


Майрагварч
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 08

14190010012



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын
2026 оны 01 дугаар сарын 12-ны өдрийн
А/З дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ФИЛАРМОНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын
2026 оны сарын 28 ны өдрийн 1/3 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ФИЛАРМОНИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмийн зорилго нь Монгол Улсын Филармони (цаашид “Филармони” гэх)-ийн чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид энэ дүрэм нийцсэн байна.

1.3.Филармони нь хөгжмийн урлагийн бүтээл туурвих, үйлдвэрлэх, түгээх чиглэлээр төрөөс баримтлах соёл, урлагийн бодлого, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын стратеги төлөвлөлттэй уялдуулан байгууллагын хөгжлийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, холбогдох байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах хөгжмийн хүрээлэн мөн.

1.4.Филармони нь хуулийн этгээд бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банканд харилцах данс, лого, тугтай байна.

Филармонийн оноосон нэр нь:

Монгол хэлээр: Монгол Улсын Филармони

Англи хэлээр: Mongolian Philharmonic

Цахим хаяг: www.philharmonic.mn, info@philharmonic.mn

1.5.Филармони нь холбогдох шийдвэрийг үндэслэн оноосон нэрийн өмнө нэрэмжит нэрийг хэрэглэж болно.

Хоёр.Байгууллагын удирдлагын тогтолцоо

2.1.Филармони нь Монгол Улсын хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны бусад шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан эрх, үүрэг, удирдлага зохион байгуулалттай байна.

2.2.Филармони нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Зөвлөлийн үйл ажиллагааг Удирдах зөвлөлийн ажиллах журмаар зохицуулна.

2.3.Удирдах зөвлөл нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шилжүүлсэн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.4. Филармонийн захирлыг ээлжийн амралттай, албан томилолттой, эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй, түр эзгүйд түүнээс эрх олгосны дагуу

чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлнэ.

2.5.Филармонийн захирлын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий зөвлөл, хороотой байж болно.

Гурав.Филармонийн зохион байгуулалтын бүтэц

3.1.Филармони нь үйл ажиллагааны үндсэн чиглэлээр төрөлжсөн дараах зохион байгуулалтын бүтэцтэй байна:

3.1.1.Захиргаа, удирдлага зохицуулалтын хэлтэс

3.1.1.1.Санхүү, хангамжийн алба;

3.1.1.2.Маркетинг, олон нийттэй харилцах алба;

3.1.2.Уран бүтээлийн хэлтэс

3.1.2.1.Симфони оркестр;

3.1.2.2.Морин хуур найрал хөгжим;

3.1.2.3.Баянмонгол биг бэнд

3.2.Филармони нь үйл ажиллагааны хэрэгцээндээ тохирсон дуу, дүрс бичлэгийн студитэй байж болно.

3.3.Эрх бүхий этгээдээс баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан төрийн үйлчилгээний албан хаагчидтай байна.

Дөрөв.Филармонийн чиг үүрэг

4.1.Филармони нь мэргэжлийн хөгжмийн урлагийг судлах, бүтээн туурвих, үйлдвэрлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.Симфони оркестр нь сонгодог хөгжмийн бүтээлийг туурвих, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1.Сонгодог хөгжмийн бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах;

4.2.2.Дан хөгжим (симфони, гоцлол ба цөөхүүл хөгжим)-ийн бүтээлийг сурталчлан таниулах, нийтийн хүртээл болгох;

4.2.3.Нийлмэл хөгжим (дуурь, балет, оратори, кантат г.м)-ийн бүтээлийг сурталчлан таниулах, нийтийн хүртээл болгох;

4.2.4.Зах зээлийн баримжаатай хөгжим (шоу, энтертайнмент, тайз, дэлгэцийн бүтээл)-ийн бүтээлийг сурталчлан таниулах, хөгжүүлэх, нийтийн хүртээл болгох;

4.2.5.Олон улсын жишигт нийцсэн симфони оркестрын бүрэлдэхүүнээр ажиллах.

4.3.Баянмонгол биг бэнд нь жазз хөгжмийн бүтээлийг туурвих, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1.Орчин үеийн жазз хөгжмийн төрөл хэлбэрийг жигд хөгжүүлж олон нийтэд сурталчлан таниулах;

4.3.2.Уламжлал, шинэчлэлийг хослуулан “Монгол жазз” төрлийг хөгжүүлэх, сэргээн туурвих;

4.3.3.Дэлхийн жишигт нийцсэн биг бэнд хөг, бүрэлдэхүүнээр ажиллах;

4.4. Морин хуур найрал хөгжим нь үндэсний, уламжлалт сонгодог болон орчин цагийн хөгжмийн бүтээлийг шинээр болон шинэчлэн туурвих, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.1. Уртын болон богино дуу, нутаг нутгийн уламжлалт татлагыг сэргээн туурвих;

4.4.2. Орчин цагийн хөгжмийн зохиолчдын бүтээлээр урын сангаа баяжуулах;

4.4.3. Дан хөгжим (соло, дуэт, трио, квартет, квинтет, цөөхүүл, найрал хөгжим)-ийн бүтээлийг шинээр болон шинэчлэн туурвих, хөгжүүлэх, олон нийтийн хүртээл болгох;

4.4.4. Нийлмэл хөгжим (мэргэжлийн дуулаач, ари романс)-ийн бүтээлийг шинээр болон шинэчлэн туурвих, хөгжүүлэх, олон нийтийн хүртээл болгох;

4.4.5. Морин хуур найрал хөгжмийн дуу дуурслыг хөгжүүлэн сайжруулах.

4.5. Соёлын үнэт зүйлийг хадгалан хамгаалах, баяжуулах, бүртгэх, цахимжуулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.5.1. Монголын болон дэлхийн хөгжмийн зохиолчдын бүтээлээр урын сан хөмрөгөө баяжуулах;

4.5.2. Урын сан дахь бүтээлийн нот, партитурыг цахим хэлбэрт оруулж бүртгэлжүүлэх;

4.5.3. Урын сан дахь нот партитурыг стандартын шаардлага хангасан өрөө тасалгаанд хадгалан хамгаалах;

4.5.4. Урын санд хадгалагдаж байгаа нот партитурын эрсдэлийн үнэлгээ хийх, илэрсэн зөрчлийг арилгах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх.

4.6. Уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлан таниулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.6.1. Бусад театр, чуулга, кино, контент зэрэг нийлмэл урлаг бүтээгчидтэй хамтран ажиллах;

4.6.2. Бусад улс, орны ижил түвшний байгууллагатай хамтран ажиллах, концерт, сургалт, мастеркласс зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.6.3. Олон улсын хөгжмийн наадамд оролцох, үндэсний соёлын өв, уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлан таниулах;

4.6.4. Аудио, дуу, дүрсний бичлэг суурьтай сурталчилгааны хэвлэлийн бүтээгдэхүүн (цомог, пянз, кассет, сонин, сэтгүүл г.м), контент бүтээх, түгээх;

4.6.5. Уран бүтээлээ цахим платформуудад байршуулан түгээх.

4.7. Бүх нийтийн хөгжмийн боловсролд зориулсан хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

4.7.1. Мэргэжлийн хөгжмийн урлагийг сурталчлан таниулах олон талт арга хэмжээг зохион байгуулах;

4.7.2. Ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудын сурагч, оюутан залууст мэргэжлийн хөгжмийн урлагийг сурталчлан таниулах лекц концертыг зохион байгуулах;

4.7.3. Хөгжмийн мэргэжлээр бүрэн дунд болон дээд боловсрол олгож байгаа сургуулиудтай хамтран ажиллаж, сурагч, оюутнуудад найрал хөгжмийн бүрэлдэхүүнд тоглох, дадлагажуулах, ур чадварыг эзэмшүүлэх ажлыг тогтмолжуулах.

4.8. Филармони нь уран бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалах чиг үүргийн хүрээнд:

4.8.1.Төсвийн зардлаар бүтээсэн уран бүтээлийг ашиглах онцгой эрхийг эдлэх бөгөөд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох журмын дагуу бүртгүүлнэ.

4.8.2.Урын сан дахь уран бүтээл, хөгжмийн зэмсэг, техник тоног төхөөрөмж, эдлэл хэрэгслийн тооллогыг жил бүр хийж, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлан баланст бүрэн тусгана.

4.9.Филармони нь чиг үүргээ чанартай, хүртээмжтэй, олон нийтийн оролцоо, нийгмийн түншлэлд үндэслэн хэрэгжүүлэхийг зорино.

4.10.Нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, түүний ажлын үр дүнг Филарманийн захирлын өмнө хариуцан тайлагнана.

Тав.Филарманийн захирлын эрх, үүрэг

5.1.Филарманийн захирал Филарманийн төсвийн шууд захирагч байна.

5.2.Филарманийн захирал нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

5.2.1.Филарманийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гадаад, дотоод үйл ажиллагаанд байгууллагыг төлөөлөх;

5.2.2.Хууль тогтоомжид заасны дагуу төсвийн шууд захирагчийн болон энэхүү дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

5.2.3.Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, удирдах, гүйцэтгэлийг хангах, хяналт тавих;

5.2.4.Байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бусад хэлбэрээр нэмэлт орлого олсон, бүрдүүлсэн тохиолдолд орлогын зохих хувийг тухайн албан хаагчид олгох асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх;

5.2.5. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, аргачлал, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх;

5.2.6.Байгууллагын болон ажилтан, албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

5.2.7.Холбогдох хууль тогтоомжид заасан эрхийн хүрээнд албан хаагчдыг томилж чөлөөлөх, хөдөлмөрийн, эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

5.2.8.Албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулах, эрх бүхий байгууллагын шагналд тодорхойлох;

5.2.9.Хууль тогтоомжид заасан бусад эрх.

5.3.Филарманийн захирал Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа тайлагнана.

Зургаа.Хөрөнгө, санхүүжилт

6.1.Улсын Филарманийн үл хөдлөх хөрөнгө бусад биет хөрөнгө.

6.1.1.Байгууллагын үндсэн хөрөнгөд тусгагдсан тайз гэрэл, техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, хөгжмийн зэмсэг, баримтат өв, бусад биет хөрөнгөтэй байна.

6.2.Улсын Филарманийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- 6.2.1.Улсын төсөв;
- 6.2.2.Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого;
- 6.2.3.Хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, буцалтгүй тусламж, төсөл хөтөлбөр;
- 6.2.4.Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

6.3.Филармони нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэж, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.

6.3.1.Хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт орлогоо захиран зарцуулна.

Долоо.Бусад

7.1.Дүрэмд Соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

7.2.Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.3.Энэ дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль, тогтоомжоор зохицуулна.

7.4.Филарманийн үйлчилгээний нөхцөл, төлбөрийг ил тод байршуулж мэдээлнэ.

----oO----